



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/16

Мандалговь

“Мал эмнэлгийн газрын албан хэрэгцээнд
тоног төхөөрөмж” нийлүүлэгчийг сонгон
шалгаруулах үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Мал эмнэлгийн газрын албан хэрэгцээнд тоног төхөөрөмж” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Д.Энхтуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Гишүүд: Ж.Чимэддулам (Иргэний төлөөлөл)
Ө.Дугармаа (Зах зээл бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн зохицуулагч)
Э.Уянга (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Л.Адъяацэрэн (Мал эмнэлгийн газрын мэргэжилтэн)

2. Үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Д.Энхтуяа)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Л.Адъяацэрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ



486710058